



[Дорнод аймгийн Сэргэлэн сумын  
Засаг даргын тамгын газар]

**СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ  
НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендершалгаруулалт/  
гэрээний нэр, дугаар:

Дорнод аймгийн Сэргэлэн сумын эрүүл мэндийн  
төвийн сэргээн засах эмчилгээнд шаардлагатай  
тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийн баримт  
бичиг ДОАССЗДТГ/202001008

Сэргэлэн сум  
2020 он

## **Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

Огноо : 2020 оны 02 дугаар сарын 07  
Тендер шалгаруулалтын нэр: **Сэргээн засах эмчилгээний тоног төхөөрөмжжийн нийлүүлэх тендериийн баримт бичиг**  
Тендер шалгаруулалтын дугаар: **ДОАССЗДТГ/202001008**

**Сэргэлэн сумын үнэлгээний хороо нь** эрх бүхий тендерт оролцогдоос “**Сэргээн засах эмчилгээний тоног төхөөрөмж**”-ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер ирүүлэх техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар өөрийн аж ахуй нэгжийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.

Тендерийг **2020 оны 03 дугаар сарын 04-ны 10 цаг 30 минутаас өмнө** Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн, 11 цаг 00 минутанд** нээнэ.

Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50000 /тавин мянга/ төгрөгийг ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө.

Төсөвт өртөг 19.550.000 /Арван есөн сая таван зуун тавин мянга/

Дотоодын давуу эрх: **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорнод аймаг Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн

2 давхарт их эмчийн өрөө

Холбоо барих утас: Б.Золжаргал 91091836

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 1.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 1.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 1.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 2.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТОӨЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТОӨЗ 1.1</b>	<p>Захиалагч нь: <b>[Дорнод аймаг Сэргээлэн сумын Засаг даргын тамгын газар]</b></p> <p>Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: <b>Дорнод аймгийн Сэргээлэн сумын эрүүл мэндийн төвийн сэргээн засах эмчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийн баримт бичиг ДОАССЗДТГ/202001008</b></p>
<b>ТОӨЗ 1.1 (а)</b>	<p>Тендерт оролцогч эрх бүхий болон гэрээ хэрэгжүүлэх чадварыг дараах бичиг баримтаар нотолж ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Тендерт оролцогч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүй бичгээр мэдээлнэ</li> <li>2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар /баталгаажуулсан байх/</li> <li>3. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл</li> <li>4. Татварын байгууллагын тодорхойлолт</li> <li>5. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт</li> <li>6. Шүүхийн байгууллагын тодорхойлолт</li> <li>7. Харицлагч банкны тодорхойлолт</li> <li>8. Тендерт гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл</li> </ol> <p><b>Санамж: ТШӨХ-д заасан материалын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно. Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байна.</b></p>
<b>ТОӨЗ 1.1 (б)</b>	Борлуулалтын хэмжээ: <b>Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй нийт үнийн дунгээс багагүй байх. /2018,2019 он/</b>
<b>ТОӨЗ 1.1 (в)</b>	Ашигтай ажилласан байх жилийн тоо: <b>Сүүлийн 2 жил /2018, 2019 он/</b>
<b>ТОӨЗ 1.1 (г)</b>	Тендерт оролцогч гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлохын тулд дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлнэ. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <b>2018 он, 2019 он</b>
<b>ТОӨЗ 1.1 (д)</b>	Гэрээг гүйцэтгэх удирдах болон техникийн голлох 1-ээс доошгүй эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженертэй байх бөгөөд чадвар, мэргэшлийг илтгэх боловсролын диплом үнэмлэх, нийгмийн дааталын дэвтрийн хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн, ажлын туршлагын талаарх мэдээллийн хамт ирүүлнэ.
<b>ТОӨЗ 2.1(а)</b>	<p>Тендер хүлээн авах захиалагчийн хаяг:</p> <p>Тендер хүлээн авах этгээд: Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) хаягаар өөрийн аж ахуй нэгжийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50000 /тавин мянга/ төгрөгийг (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ээр банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнэ.</p>
<b>ТОӨЗ 2.1 (б)</b>	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:

	<p>Огноо: [2020 оны 03 дүгээр сарын 04-ны өдөр]</p> <p>Цаг: [10 цаг 30 минут ]</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байшин, гудамжны нэр: [Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын газрын II байр “Иргэний танхим”]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: [ЗДТГ-ын II байрны “Иргэний танхим”]</p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:</p> <p>Огноо: [2020 оны 03 дүгээр сарын 04-ны өдөр]</p> <p>Цаг: [11 цаг 00 минут ]</p>
ТӨӨЗ 2.3	<p><b>Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</b></p>
ТӨӨЗ 3.1	<p>Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ.Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үнийн саналыг маягтын дагуу бэлтэн, баталгаажуулан ирүүлэх.</li> <li>2. Бараа нийлүүлэх хуваарь</li> <li>3. Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр бэлтэн, баталгаажуулан ирүүлэх.</li> <li>4. Үйлдвэрлэгчийн гэрчилгээ, олон улсын чанарын сертификатын хуулбарыг ирүүлнэ. (монгол хэл дээр орчуулсан батлагаат орчуулгын хамт)</li> <li>5. .Нийлүүлэх бараа нь үнийн саналын баримт бичиг, техникийн тодорхойлолтод нийцэж буйг нотлох дэлгэрэнгүй тодорхойлолт болон бусад баримт бичгүүдийг ирүүлэх Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Нийлүүлэх барааны зураг болон танилцуулга ирүүлэх</li> <li>• Нэмэлт ба дагалдах хэрэгслийн жагсаалт ирүүлэх</li> <li>• Тоног төхөөрөмж хүлээлгэн өгөх үед баталгаат хугацаа 12сараас багагүй байх талаар гэрээ байгуулах</li> <li>• Баталгаат хугацааны засвар үйлчилгээг ханганд нийлүүлэгч хариуцах талаар албан бичиг ирүүлэх</li> <li>• Баталгаат хунацаа дууссаны дараа сэлбэг хэрэгслээр хангах боломжтой тухай албан мэдэгдэл ирүүлэх</li> <li>• Тоног төхөөрөмжийн ашиглалт засвар үйлчилгээний талаар сургалт зохион байгуулах хуваарь ирүүлэх</li> <li>• Ашиглалтын, аюулгүй ажиллагааны, халдваргүйтгэлийн болон засвар үйлчилгээний гарын авлагын жагсаалт ирүүлэх</li> <li>• Үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалт туршилтын гэрчилгээ</li> </ul> </li> <li>6. Тендерт оролцогчийн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл ирүүлнэ.</li> <li>7. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл</li> </ol>

	<p>ирүүлэх жилийн тоо: <b>[Сүүлийн 2 жил]</b> захиалагч байгууллагын тодорхойлолт, ажил гүйцэтгэх гэрээ, ажил хүлээнлэсэн комиссын акт</p> <p>8. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: <b>тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.</b></p> <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Байгууллагын дансны үлдэгдэл харилцагч банкны тодорхойлтоор</li> <li>2. Арилжааны банкны зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт</li> </ol>
<b>ТОӨЗ 4.1</b>	Тендерт оролцгчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <b>“тохижуулахгүй тогтмол байна”</b> .
<b>ТОӨЗ 6.1</b>	Тендер нээнээс хойш <b>[30]</b> хоногийн туршид хүчинтэй байна
<b>ТОӨЗ 6.2</b>	<p>Хэрэв тендерт гадаадын этгээд оролцох эрхтэй бол тендерийн хэл нь Монгол хэлээс гадна дараах хэл дээр байна. Үүнд: <b>Монгол хэл дээр бэлтгэнэ.</b></p> <p><i>Тендерт оролцогчид дээр тодорхойлсон Монгол хэл дээр бэлтгэж ирүүлэх бөгөөд нэгээс дээш хэл дээр тендерээ бэлтгэж ирүүлэхийг хориглоно.</i></p>
<b>ТОӨЗ 7.1</b>	Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь СИР үнээс гадна дараах үнээр санал болгож болно. Үүнд: Энэ үнэнд даатгал, татвар, тоног төхөөрөмжийн баталгаажуулалт, сургалт, сууринуулалт, эцсийн цэг хүртэлх бусад бүх зардууд багтсан байна.
<b>ТОӨЗ 7.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>[байхгүй]</b>

БАТЛАВ:  
СЭРГЭЛЭН СУМЫН ЗАСАГ  
ДАРГА *Д.О.* Н.ГҮРРАГЧАА

СЭРГЭЛЭН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН СЭРГЭЭН ЗАСАХ  
ЭМЧИЛГЭЭНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоног төхөөрөмжийн зураг	Барааны техникийн үзүүлэлт	Тоо хэмжээ
1	Цахилгаан бүмбэн аппарат		<p>Хэмжээ: 360x360x220 (мм)  Жин: 8 кг  Хүчдэл: 220 Вольт ,60 герц байх  Хэрэглээний чадал: 100Вт  Хамгийн их гүйдлийн хэмжээ: 80 милли ампер (20милл/ампер X4)  Долгионы хэлбэр: трапец, гурвалжин, тэгш өнцөгт  Давтамж: 1 герц ~ 1,2 килогерц  Давтамжийн шатлал: 1 герц  Эмчилгээний программ: 6  Хугацаа: 0~99 мин байх  Хамгийн их сорох хүч: - 50 к.Па  2x4 сордог электродтой байх</p>	1 (5 200.0)
2	Хөлийн массажны аппарат		<p>Сувгууд: 8 төрөл  Даралтын хурд: 30~240 (мм м.у.б)  Үйлчлэх хугацаа: 1~90 минут  Өнгөний сонголттой байх  Функц: тунгалгийн зангилаа болон захын судасны эргэлтийг сайжруулахад зориулагдсан байх  Чадал: 65 Ватт  Хүчдэл: 220 Вольт/ 50 герц  Мөр, хөл, нуруунд бэхэлж хэрэглэнэ</p>	1 (2 800.0)

3	УВЧ (Хэт улаан туяаны аппарат)		<ul style="list-style-type: none"> <li>-Гаралтын давтамж: 40.68 мигагерц байх</li> <li>-Ажиллах цахилгаан хүчдэл нь 220 вольт</li> <li>-Цахилгаан давтамж нь 50 герц байх</li> <li>-Хугацааны тохироулга: 0-20 мин байх</li> <li>-Хэвийн гаралтын чадал: 30 Ватт байх</li> </ul>	1 (3 600.0)
4	Каскад Каскад (парафин лаа хайлуулах аппарат)		<ul style="list-style-type: none"> <li>-Халах темпратур: 75-100 градус</li> <li>-Хэмжээ:</li> <ul style="list-style-type: none"> <li>•урт-300</li> <li>•өргөн-300</li> <li>•өндөр-350</li> </ul> <li>-Хувийн жин: 6кг орчим</li> <li>-Эрчим хүчний хэрэглээ: 500 ватт</li> <li>-Цахилгаан тэжээл: 220 вольт</li> </ul>	1 (1 600.0)
5	Хаш чулуун ор		<ul style="list-style-type: none"> <li>-Дотоод төхөөрөмж нь 4-6 бүрэлдэхүүнтэй дээд зэргийн хаш чулуутай.</li> <li>-Бөмбөлөгүүдтэй хаш чулуун төхөөрөмжийг орны 2 талд нэмэлтээр биенийн хүрэлцэхгүй байгаа хэсэгт байршуулсан байх.</li> <li>-Хаш чулуун өнхрүүлэг нь 40-70 градус хүртэл халдаг байх</li> <li>Хүзүүний үе дагуух хаш чулуун өнхрүүлэгтэй байх</li> </ul>	1 (5.500.0)

6	Электрофорез		<p>-Цахилгаан тэжээл: <math>220\pm10</math> вольт</p> <p>-Цахилгаан давтамж нь 50 герц байх</p> <p>-Хэвийн гаралтын чадал: 11 Ватт байх</p> <p>-Ачаалалтай үед үйлчлүүлэгчийн хэлхээнд үүсэх гүйдэл 500 Ом үед <math>50\pm5</math>mA</p> <p>-Ачаалалтай үед үйлчлүүлэгчийн хэлхээнд үүсэх гүйдлийн давтамжийн коэффициэнт 0.5%</p>	1 (850.0)
---	--------------	---	--	--------------

- Стандарт:** Бараа нь технологийн хувьд орчин үеийн дэвшилтэд технологи байх ба олон улсын бүтээгдэхүүний чанарын CE, FDA, ISO, TUV зэрэг стандартуудын аль нэгийг хангасан байна.
- Баглаа, боодол:** Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад эвдрэх гэмтэхээс урьдчилан сэргийлэх баглаа боодлоор хангана.
- Бараа хүргэх газар:** Дорнод аймаг Сэргэлэн сум Эрүүл мэндийн төв
- Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Гэрээ байгуулагдсанаас хойш 45 хоногийн дотор нийлүүлнэ.

### **БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгч ийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Цахилгаан бүмбан аппарат		1	Ш				
Хөлийн массажны аппарат		1	Ш				
УВЧ (хэт улаан туяаны аппарат)		1	Ш				
Каскад (парафин хайлуулах аппарат)		1	Ш				
Хаш чулуун ор		1	Ш				
Электрофорез		1	Ш				

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮННИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг **[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу **[тоо]** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний өрөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших</b>	1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
<b>7. Төлбөр</b>	7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>	10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
<b>11. Маргааныг шийдвэрлэх</b>	11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>   | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b>   | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |  |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>  | 3.1. Баталгаат засварын тусгай шаардлага.<br><br>12 сараас багагүй хугацаанд баталгаатай байх шаардлагатай   |
| <br><br>  |  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 4.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Гэрээний үнийн дүнгийн <b>[100]<sup>1</sup></b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup></b>  | 6.1. Алданги оногдуулах хувь: <b>[0.5 хувь]</b><br><br>Алдангийн нийт дүн: <b>[10 хувь]</b>  |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнэ.

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>3</sup>

БАТЛАВ.

### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>3</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]